

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ**

Доны 04 сарын 28 өдөр  
Зуунмод

Дугаар 03.

Коронавируст цар тахлын үед хандив тусlamжийн хөрөнгийг  
бүртгэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой  
ЗӨВЛӨМЖ

**1. Хандив тусlamж авах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт:**

А. Төсвийн тухай хуулийн 25-р зүйлд заасны дагуу зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллагууд төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс дараах тохиолдолд хандив тусlamж авч болохоор заасан. Үүнд:

- санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх,
- байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.

Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусlamж авахыг хориглоно:

- хандив, тусlamж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх;
- байгууллагын ажилтны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусlamж өгөхийг хориглосон.

Б. Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг Улсын онцгой комисс болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд

ил тод байлгаж, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.” гэж заасан.

## **2. Хандив тусlamжийн хөрөнгийг нягтлан бodoх бүртгэлд бүртгэх, зарцуулах, тайлагнах**

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 14.4-т бүх хөрөнгийн зүйлсийг заавал бүртгэнэ гэж заасны дагуу хандив тусlamжаар ирж байгаа хөрөнгийг заавал бүртгэнэ.

Хандив нь мөнгөн болон биет хэлбэртэй байж болно. Мөнгөн хандив нь гадаадын валютаар байх үед тухайн өдрийн Монгол банкны ханшаар төгрөгт шилжүүлсэн дүнгээр илэрхийлж нягтлан бodoх бүртгэлд тусгана.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-д заасны дагуу бэлэн мөнгөөр ирсэн хандив, тусlamжийг мөнгөн касстaa бэлнээр хүлээн авч, энэхүү орлогыг /туүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.

Биет хэлбэрээр ирж байгаа хандивыг хөрөнгийн дансанд орлого авахдаа хандивлагчаас ирж байгаа зарлагын баримтыг үндэслэх бөгөөд анхан шатны баримтгүй тохиолдолд тухайн бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнээр тухайн байгууллагын дэргэдэх өмч хамгаалах комисс, эсвэл сумын үнийн комиссоор үнэлүүлэн шийдвэр гаргуулж, байгууллагын даргын тушаалаар орлогод авна. Цаанаасаа үнэгүй ирсэн юм гэсэн байдлаар хандаж, хөрөнгийг бүртгэхгүй орхигдуулж болохгүй.

Дансны бичилтийн хувьд:

Төсөвт байгууллага нь хандив, тусlamжаар хүлээн авсан хөрөнгийг холбогдох анхан шатны бүртгэлд тусгаж, тайлант хугацаанд санхүүгийн тайланд дараах байдлаар бүртгэж тайлагнана.

а. Мөнгөөр хүлээн авсан үед:

Дт. Мөнгөн хөрөнгө

Кт. Хандив, тусlamжийн орлого

б. Мөнгөн бус хөрөнгө хүлээн авсан үед зах зээлийн үнээр эсвэл гэрээнд заасан үнээр, хандивлагчийн зарлагын баримтыг үндэслэн бүртгэнэ:

Дт. Бараа материал

Кт. Хандив, тусlamжийн орлого

Хандиваар ирсэн хөрөнгийг зарцуулахдаа төсвийн хөрөнгийн нэгэн адил Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны буртгэлийн маягт”-ыг бүрдүүлсний үндсэн дээр олгогдоно.

Тусlamжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална. Тусlamж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу буртгэж, гүйцэтгэлийг тайлagnана. Төсвийн тухай хуулийн 47-р зүйлд зааснаар Төсвийн захирагч нь төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусlamжийг нэмэлт төсвийн дансанд байршуулж холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно. Нэмэлт төсөв, хандив тусlamжтай холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч тусlamж, хандив авсан тухай баримтыг аймгийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ.

### **3.Хандив тусlamжийн хөрөнгийн ил тод байдлыг хангаж ажиллах:**

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өгч байгаа хандивыг ил тод байлгахын тулд төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нар Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.2.7. хандив, тусlamжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL.XML форматаар тус тус цахимаар; “Шилэн данс”-ны Төсөв/гүйцэтгэл цэсний хандив тусlamжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (хагас жилээр, бүтэн жилээр) –д мэдээлнэ. Сумдын Засаг дарга наарт болон сумын Онцгой комиссын нэр дээр ковидтой холбоотой ирсэн хандив тусlamжийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, тухайн байгууллагын “Шилэн данс”-нд мэдээлнэ.

2. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д заасны дагуу хандив тусlamжийн бүрдүүлэлт болон зарцуулалтыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх шаардлагатай.

### **4.Хандив тусlamжийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт,**

#### **ил тод байдалд хяналт тавих :**

1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу томилогдон ажиллаж байгаа тухайн сум,

байгууллагын дотоод хяналтын комиссын зүгээс удирдамж гарган батлуулж, дотоод хяналтыг явуулж болно.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс Санхүүгийн хяналт, аудитын алба дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

3. Хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

